



НУУЦЛАЛЫН БОДЛОГО

Энэхүү Нууцлалын бодлогоор “Стор пэй ББСБ” ХХК /цаашид “Мэдээлэл хариуцагч” гэх/-ийн үйлчилгээ /цаашид “Үйлчилгээ” гэх/-г ашиглаж буй Хэрэглэгчийн мэдээлэл (хэрэглэгч хувь хүн бол хувийн мэдээлэл, байгууллага бол байгууллагын мэдээллийг хамааруулна)-ийг цуглуулах, боловсруулах, дамжуулах, ашиглах, хадгалах, устгахтай холбоотой харилцааг зохицуулна.

Мэдээлэл хариуцагч нь Хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй, халдашгүй байдлыг хамгаалах бөгөөд хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, дижитал үйлчилгээний аюулгүй байдал, цахим гүйлгээ, төлбөрийн болон төлбөрийн картын гүйлгээ, мэдээлэл хадгалалт, дамжуулалттай холбоотой үйл ажиллагаандаа Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

Хэрэглэгч та мэдээлэл хариуцагчаас санал болгож буй бүх төрлийн үйлчилгээний нөхцөл, бодлого зэрэгтэй бүрэн танилцсаны үндсэн дээр өөрийн сонгосон үйлчилгээг ашиглахдаа Хэрэглэгчийн мэдээллийг Мэдээлэл хариуцагч хүлээн авах, хадгалах, цуглуулах, боловсруулах, дамжуулах, энэхүү бодлогод заасны дагуу ашиглах зэрэг зөвшөөрөл олгох эсэхийг хараат бусаар, бие даан шийдвэрлэнэ үү.

Хэрэглэгч энэхүү нууцлалын бодлогыг сайтар уншиж танилцсан байх үүрэгтэй бөгөөд танилцаагүйгээс үүдэн гарах аливаа асуудалд Мэдээлэл хариуцагч хариуцлага хүлээхгүй болно.

Нууцлалын бодлогод түсгасан нөхцөлүүдийг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа тохиолдолд “Зөвшөөрөх” гэсэн хэсгийг идэвхжүүлснээр мэдээлэл хариуцагчид Хэрэглэгчийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах, дамжуулах, устгах цахим зөвшөөрлийг олгосон гэж үзнэ.

1. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, дамжуулах, ашиглах үндэслэл, зорилго

- 1.1. Нууцлалын бодлогын дагуу Хэрэглэгчийн мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрлөөр хүлээн авч, хадгалах, цуглуулж, боловсруулж, дамжуулж, ашиглана.
- 1.2. Үйлчилгээг ямар нэгэн саадгүйгээр Хэрэглэгчид шууд хүргэх, хэрэглэгчийн бүртгэлийг үүсгэх, бүртгэл хөтлөх, танин баталгаажуулах (KYC) зорилгоор Хэрэглэгчийн мэдээллийг хүлээн авч, цуглуулж, боловсруулж, хадгалж, дамжуулж, ашиглана.
- 1.3. Нууцлалын бодлогод заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:
 - 1.3.1. “Хэрэглэгчийн мэдээлэл” гэж Хэрэглэгчийг таньж, тодорхойлох боломжтой шууд болон шууд бус мэдээллийг, Тухайлбал, хүний хувийн мэдээлэл, масклагдсан биометрик мэдээлэл зэрэг хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд заасан мэдээллийг ойлгоно.

- 1.3.2. **“Биометрик мэдээлэл”** гэж хэрэглэгчийг танин баталгаажуулах, залилах болон бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглаж буй хэрэглэгчийн нүүр царайны бодит цагийн дүрс мэдээллийг хэлэх бөгөөд уг мэдээллийг хэрэглэгчийн өөрийнх нь ХУР системээс татуулсан зурагтай нь харьцуулан баталгаажуулна.
- 1.3.3. **“Мэдээлэл цуглуулах”** гэж мэдээллийг олж авах, бүрдүүлэх, бүртгэх үйл ажиллагааг;
- 1.3.4. **“Мэдээлэл боловсруулах”** гэж мэдээллийг ангилах, хадгалах, дүн шинжилгээ хийх, хэрэглэгчийн хүсэлтээр өөрчлөх, устгах, сэргээх үйл ажиллагааг;
- 1.3.5. **“Мэдээлэл ашиглах”** гэж мэдээлэл цуглуулах, боловсруулахаас бусад хэлбэрээр Мэдээлэл хариуцагч үйл ажиллагаандаа хэрэглэх, дамжуулах болон мэдээлэлтэй танилцах үйл ажиллагааг;
- 1.3.6. **“Мэдээлэл хариуцагч”** гэж “Стор пэй ББСБ” ХХК-ийг;
- 1.4. Мэдээлэл хариуцагч нь үйлчилгээгээ сайжруулах зорилгоор Хэрэглэгчийн мэдээллийг нэмэлтээр цуглуулж болно.

2. Цуглуулах, боловсруулах, ашиглах

мэдээллийн жагсаалт

- 2.1. Хэрэглэгчийн мэдээллийг Стор пэй аппликейшныг ашиглах, түүгээр дамжуулан үйлчилгээг үзүүлэх явцад цуглуулж, боловсруулж, ашиглана.
- 2.2. Хэрэглэгч Стор пэй аппликейшнд нэвтэрсэн үеэс эсхүл Мэдээлэл хариуцагчаас санал болгож буй үйлчилгээг ашиглах бүрт Хэрэглэгчийн мэдээллийг цуглуулна.
- 2.3. Хэрэглэгч мэдээллээ бүрэн бүтэн, үнэн, зөв оруулах үүрэгтэй ба мэдээллээ буруу, дутуу эсхүл зөрүүтэй оруулсан тохиолдолд Үйлчилгээг ашиглах боломжгүй болно.
- 2.4. Хэрэглэгчийн дараах хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглана. Үүнд:
 - 2.4.1. Үйлчилгээг ашиглах үед Хэрэглэгчээс Стор пэй аппликейшнд оруулсан дараах мэдээллүүд:
 - 2.4.1.1. Хэрэглэгчийг танин баталгаажуулах зорилгоор бүртгэл үүсгэхэд оршин суугаа хаяг, одоо цагийн өөрийн зураг, гар утасны дугаар, цахим шуудангийн хаяг, иргэний үнэмлэхийн зураг, гарын үсэг, биометрик мэдээлэл, ажлын газрын мэдээлэл, боловсролын зэрэг, хүүхдийн тоо, гэрлэлтийн байдал, баримт бичиг болон тэдгээрт агуулагдаж буй бусад мэдээллүүд;
 - 2.4.1.2. Хэрэглэгчийн буюу хувь хүний овог, нэр, төрсөн он сар, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт буюу орлогын мэдээлэл болон ХУР системээр дамжуулан баталгаажуулсан бусад мэдээлэл;
 - 2.4.1.3. Хэрэглэгчийн бүртгэлд хамаарах нэвтрэх нэр, масклагдсан нууц үг, масклагдсан худалдан авалтын гүйлгээний нууц үг;
 - 2.4.1.4. Хэрэглэгчтэй холбогдох боломжгүй тохиолдолд эсхүл яаралтай үед холбогдох 2 хүний овог, нэр, утасны дугаар, ямар холбоотой болон улс төрд нөлөө бүхий этгээд эсхүл улс төрд нөлөө бүхий этгээдийн хамаарал бүхий хүн гэх зэрэг мэдээллүүд. Хэрэглэгчтэй яаралтай үед холбогдох 2 хүний мэдээллийг оруулсан нь тус 2 хүнээс зөвшөөрөл олгосон гэж үзнэ;
 - 2.4.1.5. Хэрэглэгч үйлчилгээтэй холбоотой аливаа төрлийн ухаалаг төхөөрөмж ашиглаж Мэдээлэл хариуцагчийн цахим хуудас болон олон нийттэй харилцдаг сувгуудаар дамжуулан холбогдоход ашиглагдсан таны IP хаяг зэрэг мэдээллүүд;

- 2.4.1.6. Хэрэглэгчийн зээлийн мэдээллийн сангийн лавлагаа болон зээлжих чадварын зэрэглэлийн мэдээлэл.
- 2.4.2. Хэрэглэгч үйлчилгээг ашиглах явцад үүсэх мэдээллүүд:
 - 2.4.2.1. Банкны данс, кредит болон дебит карт, гүйлгээний түүх, худалдан авалтын түүх, худалдан авалтын төлбөр төлөлтийн мэдээлэл, SPCFIN токен байршуулсан, зарлага хийсэн крипто хаягийн мэдээлэл, SPCFIN токенод суурилсан үйлчилгээ авч буй тохиолдолд үүссэн мэдээллүүд;
 - 2.4.2.2. Хэрэглэгчээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдол, түүнийг шийдвэрлэхэд хамаарах мэдээллүүд.
- 2.5. Үйлчилгээг илүү ухаалаг, хялбар байлгах зорилгоор хөгжүүлж, боловсронгуй болгохоос гадна Стор пэй аппликейшнд хандсан зөвшөөрөлгүй хандалтыг тодорхойлох үүднээс Хэрэглэгчийн дараах мэдээллүүдийг тухай бүр автоматаар цуглуулж болно. Үүнд:
 - 2.5.1. Газар зүйн байршил, ашиглаж буй үйлдлийн систем, веб хөтчийн нэр, IP хаяг, сүлжээний протокол, Стор пэй аппликейшнд нэвтэрсэн хугацаа;
 - 2.5.2. Хэрэглэгчийг баталгаажуулах нэг удаагийн код, гүйлгээний нууц үг, бүртгэлийн мэдээлэл;
 - 2.5.3. Хэрэглэгчийн хандалт хийсэн, баталгаажуулсан төхөөрөмжийн мэдээлэл, газар зүйн ямар байршлаас хандсан зэрэг мэдээлэл;
 - 2.5.4. Бусдад хуваалцсан болон сэтгэгдэл үлдээсэн мэдээллүүд;
 - 2.5.5. Стор пэй аппликейшнд нэвтэрсэн байдлыг хэвээр хадгалж буй тохиолдлууд.

3. Мэдээлэл боловсруулах, ашиглах

- 3.1. Хэрэглэгчийн хэрэгцээнд тулгуурлан Үйлчилгээг байнга сайжруулах, хөгжүүлэх, боловсронгуй болгох, кибер халдлага болон бусад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, залилан мэхлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд Хэрэглэгчийн мэдээллийг дараах тохиолдлуудад боловсруулж, ашиглана. Үүнд:
 - 3.1.1. Үйлчилгээг үзүүлэх хүрээнд:
 - 3.1.1.1. Хэрэглэгчийг танин, баталгаажуулах явцад;
 - 3.1.1.2. Хэрэглэгчийн үйлчилгээний эрх нээх эсэх шийдвэр гаргах явцад;
 - 3.1.1.3. Үйлчилгээг сайжруулах судалгаа хийх болон судалгаанаас гарсан дүгнэлтийг хэрэгжүүлэх бүрт;
 - 3.1.1.4. Үйлчилгээг үзүүлэх бүрт;
 - 3.1.1.5. Гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний үүргийг хэрэгжүүлэх хүрээнд;
 - 3.1.1.6. Стор пэй аппликейшныг хөгжүүлэх, сайжруулах зорилгоор;
 - 3.1.1.7. Маркетингийн үйл ажиллагаа зохион байгуулах тохиолдолд;
 - 3.1.1.8. Үйлчилгээний нөхцөлд заасан эрх, үүргийн хэрэгжилтэд дотоод, хяналт шалгалт хийх явцад;
 - 3.1.1.9. Үйлчилгээний талаарх мэдээллийг Хэрэглэгчид цахимаар болон утсаар холбогдож хүргэх бүрт;
 - 3.1.1.10. Үйлчилгээний шинэчлэл, сайжруулалтын мэдээллээр хангах хүрээнд.
 - 3.1.2. Залилан мэхлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх хүрээнд;

- 3.1.2.1. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор;
- 3.1.2.2. Үйлчилгээнд холбогдох асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор;
- 3.1.2.3. Үйлчилгээний аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хэрэглэгчдэд хүртээмжтэй байлгах ажлыг зохион байгуулах зорилгоор;
- 3.1.2.4. Хэрэглэгчээс ирүүлсэн болон Хэрэглэгчид холбогдох гомдлыг хянан шалгах зорилгоор;
- 3.1.2.5. Хэрэглэгчийн мэдээллийн үнэн зөв байдлыг шалгах, шаардлагатай тохиолдолд гуравдагч этгээдээс өгсөн мэдээлэлтэй харьцуулан шалгах зорилгоор;
- 3.1.2.6. Аудитын шалгалт болон хууль, шүүхийн байгууллагаар хэрэг маргааныг хянан шалгах, шийдвэрлэх хүрээнд;
- 3.1.2.7. Мэдээлэл хариуцагч нь хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, систем, сүлжээ, аппликейшн, дижитал үйлчилгээний аюулгүй байдлыг хангах зорилгоор Кибер аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн шифрлэлт, сүлжээний хамгаалалт, логийн хяналт, эрхийн түвшний хандалт, тогтмол аудит, мониторинг, халдлага илрүүлэх болон хариу арга хэмжээний хяналтуудыг хэрэгжүүлнэ.

4. Мэдээллийг нийтэд ил болгох нөхцөл

- 4.1. Хуульд заасан тохиолдолд зөвхөн төрийн эрх бүхий байгууллагын шаардлагаар хэрэглэгчийн мэдээллийг нийтэд ил болгоно.
- 4.2. Хуульд өөрөөр заагаагүй бол 4.1-т зааснаас бусад тохиолдолд Мэдээлэл хариуцагч нь хэрэглэгчийн мэдээллийг задруулахгүй бөгөөд мэдээллийн нууцыг хамгаална.

5. Мэдээллийг дамжуулах

- 5.1. Хэрэглэгч өөрийн хүлээн зөвшөөрсөн үйлчилгээний нөхцөлийг зөрчсөн болон худалдан авалтын төлбөр төлөлтийн хугацаа хэтрүүлсэн бол хэрэглэгчийн мэдээллээс шаардлагатай мэдээлэл /нэр, зураг, биелэгдээгүй үүрэг гэх мэт үүгээр хязгаарлагдахгүй/-ийг хууль, шүүхийн болон холбогдох, гуравдагч байгууллагад нууц хадгалах гэрээний дагуу дамжуулна.
- 5.2. Мэдээлэл хариуцагч нь хэрэглэгчийн мэдээллийг Стор пэй аппликейшны тасралтгүй, найдвартай, хэвийн ажиллагааг хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шинэ бүтээгдэхүүн гаргахтай холбоотойгоор энэхүү нууцлалын бодлогын 2.4, 2.5-д заасан болон дараах мэдээллийг хөгжүүлэгч байгууллагад дамжуулна.
 - 5.2.1. Стор пэй аппликейшнд нэвтрэх үед хийж буй тогтмол үйлдэл, үйлчилгээний сонголтын бүртгэлийн мэдээлэл.
- 5.3. Хэрэглэгчийн Стор пэй үйлчилгээний нөхцөлөөр хүлээн зөвшөөрсөн төлбөрийн үүргийн мэдээллийг Зээлийн мэдээллийн санд нийлүүлж, дамжуулна.
- 5.4. Мэдээлэл хариуцагч нь хэрэглэгчийн мэдээллийг гуравдагч этгээд болох ханган нийлүүлэгч, хөгжүүлэгч байгууллага, аутсорсинг үйлчилгээ үзүүлэгч, интеграцчилсан үйлчилгээ, аппликейшн болон бусад холбогдох этгээдүүдэд дамжуулах, хандах болон боловсруулах эрх олгох тохиолдолд тухайн этгээдээс энэхүү Нууцлалын бодлого, Компанийн мэдээллийн аюулгүй байдлын шаардлага, мөн Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг шаардана.

5.5. Энэхүү бодлогын 5.4-т заасан этгээдүүдэд тавигдах мэдээллийн хамгаалалт, нууцлал, хадгалалт, устгал, мэдээллийн зөрчлийн талаар мэдэгдэх, зөвшөөрөлгүй ашиглахгүй байх, мөн зөвхөн зориулалтын хүрээнд боловсруулах шаардлагуудыг гэрээ, нууцлалын гэрээ, үйлчилгээний түвшний гэрээ, аюулгүй байдлын хавсралт болон бусад холбогдох баримт бичигт тусгана.

6. Мэдээллийн нууцлал, хадгалалт

- 6.1. Хэрэглэгчийн өөрийн оруулсан болон үйлчилгээг авах явцад үүссэн хэрэглэгчийн мэдээлэл, гүйлгээний мэдээлэл, төлбөр төлөлттэй холбоотой мэдээллийг хамгаалалт бүхий мэдээллийн системд хадгална.
- 6.2. Мэдээлэл хариуцагч нь хэрэглэгчийн мэдээллийн бүрэн бүтэн байдал алдагдах, бүртгэлд зөвшөөрөлгүй нэвтрэх, мэдээллийг задруулах эрсдэлийг бууруулах үүднээс технологийн шийдэл болон аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллана.
- 6.3. Хэрэв хэрэглэгч өөрийн хайхрамжгүй үйлдлээс болж Стор пэй аппликейшнд нэвтрэх мэдээллээ алдсан эсхүл бусдад өөрийн мэдээллээ шилжүүлсэн, ашиглуулсан тохиолдолд үүсэх үр дагаврыг хэрэглэгч өөрөө хариуцна.
- 6.4. Хэрэглэгч Стор пэй аппликейшнд нэвтрэх нэр, нууц үг, баталгаажуулах нэг удаагийн код, гүйлгээний нууц үг зэрэг өөрийн мэдээллийг бусдад дамжуулахгүй, ашиглуулахгүй, нийтэд мэдээлэхгүй байх үүрэг хүлээнэ.
- 6.5. Хэрэв хэрэглэгч хувийн мэдээллээ алдсан эсхүл гуравдагч этгээд хэрэглэгчийн бүртгэлд нэвтэрсэн байх тохиолдолд хэрэглэгч мэдсэн даруй customer_voice@storepay.mn и-мэйл хаягаар, албан ёсны нийгмийн сүлжээний сувгууд болон 7611-0111 дугаарын утсаар өдөр бүр 09:00-22:00 цагийн хооронд мэдэгдэх үүрэгтэй.
- 6.6. Кибер халдлага, системийн гэмтэл, ажилтны буруутай үйл ажиллагаа, эсхүл программ хангамж болон мэдээллийн санд гэмтэл гарсны улмаас хэрэглэгчийн мэдээлэл алдагдсан тохиолдолд бид хэрэглэгчийн бүртгүүлсэн и-мэйл хаяг, гар утасны дугаарт нэн даруй мэдэгдэл хүргүүлнэ. Хэрэглэгч мэдэгдэлд заасан заавар, анхааруулгын дагуу арга хэмжээ авах үүрэгтэй.
- 6.7. Интернэт сүлжээ, и-мэйл, зурвас болон мессенжерээр дамжуулан хэрэглэгчээс илгээж буй мэдээллийн нууцлалын аюулгүй байдлыг Мэдээлэл хариуцагч нь хангах боломжгүй тул хэрэглэгч өөрөө аюулгүй байдлаа хамгаална.
- 6.8. Мэдээлэл хариуцагч нь хэрэглэгчийн мэдээллийг компанийн дотоод журам, зохицуулагч байгууллагын шаардлагын дагуу болон хуульд заасан хугацаанд хадгална.
 - 6.8.1 Хэрэглэгчийн мэдээлэл, гүйлгээний мэдээлэл, төлбөрийн болон төлбөрийн картын гүйлгээтэй холбоотой бүртгэл, лог, лавлагаа, дуудлагын бичлэг болон холбогдох өгөгдлийг хууль тогтоомж, дотоод журам болон эрх бүхий байгууллагын шаардлагад нийцсэн хугацаанд хадгална.
 - 6.8.2 Хадгалалтын хугацаа дууссан мэдээллийг устгах, архивлах, эсхүл хуульд зөвшөөрөгдсөн хэлбэрээр цаашид боловсруулах бөгөөд энэ үйл ажиллагааг баримтжуулсан процессын дагуу хэрэгжүүлнэ.
- 6.9. Мэдээлэл хариуцагч нь Үйлчилгээг сайжруулах зорилгоор Хэрэглэгчийн лавлах утсанд холбогдсон дуудлагын бичлэгийг 60 хоногийн хугацаагаар хадгална.
- 6.10. Мэдээлэл хариуцагч нь мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд шифрлэлт, сүлжээний хамгаалалт, лог хяналт, эрхийн түвшний хандалт, тогтмол аудит зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7. Насанд хүрээгүй хүний хувийн мэдээллийг хамгаалах

- 7.1. Мэдээлэл хариуцагч нь 18 насанд хүрээгүй иргэний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж, хадгалахгүй бөгөөд энэ тохиолдлыг мэдсэн даруй үйлчилгээг шууд зогсоож, мэдээллийг устгах арга хэмжээг яаралтай авна.

8. Хэрэглэгчийн мэдээллийн эрхийн хамгаалалт

- 8.1. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хэрэглэгч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
- 8.1.1. Бүртгэлээ устгах болон цаашид хэрэглэгчийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахгүй байхыг шаардах;
 - 8.1.2. Стор пэй аппликейшн дахь өөрийн хувийн мэдээлэлтэй танилцах;
 - 8.1.3. Хэрэглэгчийн хувийн мэдээллийг боловсруулах, ашиглахыг нууцлалын бодлогод заасны дагуу ашиглахыг шаардах;
 - 8.1.4. Өөрийн хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд Мэдээлэл хариуцагчид мэдэгдэх;
 - 8.1.5. Хуульд заасан үндэслэлээр тодорхой хувийн мэдээллийг өөрчлөх, засварлах, устгахыг шаардах;
- 8.2. Хэрэглэгчийн гаргасан Хэрэглэгчийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах, цахим зөвшөөрлийг цуцлах хүсэлтийг Мэдээлэл хариуцагч ажлын 14 хоногийн дотор судалж хариу мэдэгдэнэ.
- 8.3. Хэрэв Хэрэглэгч энэхүү Нууцлалын бодлогын дагуу бүртгэлээ устгуулсан тохиолдолд Үйлчилгээг ашиглах боломжгүй бөгөөд Хэрэглэгчийн хүсэлтийг хүлээн авсан эсэхээс үл хамаарч хүсэлт гаргахаас өмнө цуглуулсан энэхүү бодлогын Хоёрдугаар бүлэгт тодорхойлон цуглуулсан мэдээллийг хуульд заасан хугацаагаар хадгална.

9. Нууцлалын бодлогын шинэчлэлт

- 9.1. Үйлчилгээг үзүүлж байх хугацаанд Нууцлалын бодлогод нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлд орсон өөрчлөлтийг дагаж мөрдөнө.
- 9.2. Энэхүү бодлогод нэмэлт, өөрчлөлт орсны дараа мэдээлэл хариуцагч нь хэрэглэгчдэд Стор пэй аппликейшнээр дамжуулан өөрчлөлтийг мэдээнэ.
- 9.3. Мэдээлэл хариуцагч нь Нууцлалын бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулсан даруйд www.storepay.mn вебсайтын нүүр хэсгийн хамгийн доор байрлах “Нууцлалын бодлого” хэсэгт, Стор пэй аппликейшны “Бичиг баримт” цэсэд байрлах “Нууцлалын бодлого” хэсэгт тус тус Хэрэглэгчид зориулж нээлттэйгээр нийтэлнэ.
- 9.4. Хэрэглэгч болон Мэдээлэл хариуцагчийн хооронд маргаан үүсвэл маргаанд Стор пэй үйлчилгээний нөхцөл болон энэхүү Нууцлалын бодлогыг баримтална.

НУУЦЛАЛЫН БОДЛОГОТОЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРӨВ.